


X-Lite 3.0 тохиргоо

X-Lite програм ашиглан яриа хийх үед яриа тасрах асуудал гардаг. Яриа хийж байх явцад тасрах хугацаа нь харилцан адилгүй байдаг ба 1 минут, 3 минут, 10 минут, 19 минут гэх мэт. Энэ үед дараах тохиргоог шалгах хэрэгтэй.


1. Тохиргоо хийхийн тулд доошоо харсан гурвалжин хэлбэртэй товчлуур дээр дарж **Sip Account Settings** цэс рүү орно.




2. Дараах цонх гарч ирэхэд **Properties** товчлуур дээр дарна.




3. Тохиргооны цонх гарч ирэхэд **Topology** товч дээр дарна.



4. IP address хэсгээс **Use local ip address**-ийг сонгоно.



5. **Advanced** хэсэгт ороод дараах тохиргоог хийнэ.



Х-lite анх суухдаа **reregister every** нь 3600 байдаг ба **90** болгон

Enable session timers-ийг чагтална.

Дээрхи тохиргоог хийсний дараа **OK** дараад програмаа **restart** хийх хэрэгтэй.

Хэрвээ таньд ямар нэг асуудал гарвал 98102000 дугаар болон gnetphone@yahoo.com мессенжерийн хаягтай холбогдоно уу. /24 цаг/

X-Lite 3.0 тохиргоо

X-Lite гадагшаа залгаж болж байгаа хэрнээ гаднаас дуудлага авахгүй байгаа бол дараах тохиргоог шалгах хэрэгтэй.

1. Xlite-ийн дэлгэцийн доор байрлах **DND** гэсэн товчны гэрэл ассан үед гаднаас дуудлага авахгүй ба Xlite-ийн дэлгэц дээр **Do-not-disturb enabled** гэсэн бичиг гарсан байдаг.



DND товч дээр дарж шар гэрлийг унтраана.

- 2.





Xlite-ийн дэлгэц дээр **Do-not-disturb disabled** гэсэн бичиг гарсан бол та гаднаас дуудлага хүлээн авах боломжтой болно.


X-Lite 3.0 нэг талын яриа сонсогдохгүй үед хийх тохиргоо

X-Lite програм дээр таны компьютерийн дууны төхөөрөмжүүд (чихэвч, микрофон, спикэр) буруу тохируулагдсанаас яриа сонсогдохгүй байх асуудал гардаг. Үүнийг програм дээрээ тохируулж болно.


1. Control panel-ний **Sounds and Audio Devices** –руу орно.



2. Дараах цонх гарч ирэх ба **voice** гэсэн хэсгэрүү орно.



3. Компьютер дээр ажиллаж байгаа speaker, microphone




Дээрхи хэсэгт таны компьютер дээр ажиллаж байгаа speaker, microphone-ийг тодорхойлсноор Xlite-дээр зөв тохиргоо хийх боломжтой болох юм.

4. Xlite-ийн дээд хэсэгт байх доошоо харсан гурвалжин товч дээр дарж Options хэсэгт орно.




5. Дараах цонх гарч ирэх ба **Devices** товч дээр дарна.



6 . Тохигоо хийх цонх

Өөрийн компьютер дээр ажиллаж байгаа speaker, microphone-ийг Xlite дээр сонгоно. /Зураг-3/



Дууны төхөөрөмжөө сонгон **OK** дараад програмаа **restart** хийгээд шалгаж үзээрэй.

X-Lite 3.0 програм дээр гардаг алдаа

1. Registration error : 401



Хэрвээ 401 гэсэн алдаа зааж байвал

дугаар болон нууц үгээ буруу оруулсан байна гэсэн үг юм. Та нууц үгээ мэдэхгүй байгаа бол манай Улаанбаатар хотын төв шуудангийн хойно байрлах үйлчилгээний 3-р салбараас анх дугаар авсан хүний бичиг баримтаар Монгол дахь төлөөлөгчөөр дамжуулж авч болно. Мөн online-аар нууц үгээ авах бол өөрийн бичиг баримтыг сканнердаад internetphone@g-mobile.mn хаягруу мэйл бичиж хүсэлтээ гаргах ба ажлын өдрөөр/Даваа-Баасан/ таньд мэйлээр хариу ирэх болно.

2. Registration error : 403



Хэрвээ 403 гэсэн алдаа зааж байвал

1. Таны дугаар давхар тохируулагдсан гэсэн үг. Эсвэл таны компьютер дээр хоёр өөр яриа хийдэг програм суугаад, дугаараа давхар бүртгэсэн бол ингэнэ. Жишээ нь: 3схphone, Xlite програмууд давхар суусан бол ийм алдаа заах ба програмаа exit гээд хааж байгаад Xlite програмаа шинээр нээх хэрэгтэй. Эсвэл Xlite-ийн menu-> Sip account setting хэсэгт орж тохируулсан дугаараа устгаад шинээр тохируулах хэрэгтэй.
2. Мөн яриа хийгээд бүрэн салаагүй байхад дараагийн дугаарлуу залгасан үед error-403 гэсэн алдаа заана. Ийм үед та Xlite програмаа menu->exit гэж гараад шинээр нээх хэрэгтэй:

3. Registration error : 408



Хэрвээ error-408 гэсэн алдаа зааж байвал

1. Username дээр дугаараа буруу оруулсан бол, эсвэл дугаараас өөр юм бичсэн бол.
2. Domain code буруу оруулсан бол - /203.91.115.91 байх ёстой/
3. Мөн та domain хаяг зөв оруулсан бол доод талд байх Register with domain... гэдгийг чагталсан эсэхээ шалгах хэрэгтэй. Чагтлаагүй бол ийм алдаа заана.
4. Дээрхи бүгдийг зөв тохируулсан үед error-408 гэсэн алдаа зааж байвал таны ашиглаж байгаа интернет сүлжээнээс шалтгаалж алдаа зааж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл таны интернет сүлжээнд ямар нэг хязгаарлалт байна гэсэн үг. Жишээ нь: Sip протоколын udp/tcp 5060 порт хаалттай бол энэ алдаа заана. Tegeheer ta suljeegee soliod uzech heregtei , esvel internet hariutssan gazartaigaa holbogdoj ene talaar lavlah heregtei yumaa.

4. Registration error : 503



Хэрвээ error-503 гэсэн алдаа зааж байвал

1. Та дугаараа бүртгэхдээ domain гэдэг дээр **203.91.115.91** хаягийг зөв оруулаагүй бол
2. Мөн та domain хаяг зөв оруулсан бол доод талд байх Register with domain... гэдгийг чагталсан эсэхээ шалгах хэрэгтэй. Чагтлаагүй бол ийм алдаа заана.
3. Дээрхи тохиргоог зөв хийсэн боловч error-503 гэсэн алдаа зааж байгаа бол Xlite програмыг устгаад 3схphone програмыг суулган дугаараа тохируулах хэрэгтэй.

5. Registration error : 404



Хэрвээ error-404 гэсэн алдаа зааж байвал

Таны дугаарын ашиглах хугацаа дуусаад манай систем дээрээс утсан гэсэн үг. Дугаарын ашиглах хугацаа дуусаад цэнэглээгүй 90 хоног өнгөрсөн бол ийм алдаа заана. Та ийм алдаа заасан үед **98102000** /24 цаг/ утсанд холбогдож дугаараа шалгуулах хэрэгтэй.